



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 01 сарын 06 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Соёлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг:

“38.1.Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 6.10-г заасан зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ.”

2/38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг:

“38.4.Соёлын ажилтны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Соёлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР